

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа

Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/133/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.11 № 17

танай _____ -ны № _____ -т

ШАРГА СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.БАТТОГТОХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 1743 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн ба өмнөх оны авлага барагдуулж 38,683.7 мянган төгрөгийг санхүүжилт олгосон байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,277.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар ирсэн 97,042.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авсан.

Аудитын гол асуудал

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 838,074.9 мянган төгрөгийн нэхэмжилснээс 819,269.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдэж, 3,063.1 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж, 15,742.1 мянган төгрөгийг авлагаар тайлагнасан байна.

822505000051

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 7 зорилтын хүрээнд 94 арга хэмжээ хэрэгжүүлэхээр сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 82.0 хувь байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлт 84.0 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан СТА-1 (төгрөгөөр)

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--|------------------|------------------|
| МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 525,443.32 | 1,885,867.61 |
| Банканд байгаа бэлэн мөнгө/ төгрөгөөр/ | 525,443.32 | 1,885,867.61 |
| Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгө | 525,443.32 | 1,885,867.61 |
| АВЛАГА | 38,683,719.98 | 15,742,097.29 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 38,683,719.98 | 15,742,097.29 |
| БАРАА МАТЕРИАЛ | 36,783,308.00 | 36,458,015.18 |
| Түүхий эд материал | 30,231,308.00 | 31,955,315.18 |
| Тусгай зориулалттай материал | 275,000.00 | 2,342,193.18 |
| Эм боох материал | 29,956,308.00 | 29,613,122.00 |
| Хангамжийн материал | 6,552,000.00 | 4,502,700.00 |
| Бичиг хэргийн материал | 303,500.00 | 164,000.00 |
| Аж ахуйн материал | 775,500.00 | 398,500.00 |
| Сэлбэг хэрэгсэл | 2,000,000.00 | - |
| Түлш, шатах тослох материал | 1,382,200.00 | - |
| Хүнсний материал | 1,518,800.00 | 3,368,200.00 |
| Бусад хангамжийн материал | 572,000.00 | 572,000.00 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 75,992,471.30 | 54,085,980.08 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,763,655,918.63 | 1,608,053,399.90 |
| Биет хөрөнгө | 1,750,501,918.63 | 1,598,949,399.90 |
| Барилга, байгууламж, орон сууц | 1,487,884,069.68 | 1,286,146,713.07 |
| Хуримтлагдсан элэгдэл | (227,159,603.22) | (177,621,073.81) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 291,174,366.47 | 355,889,031.78 |
| Хуримтлагдсан элэгдэл | (35,000,000.03) | (83,613,960.99) |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 207,629,221.76 | 214,011,273.70 |
| Хуримтлагдсан элэгдэл | (84,828,952.34) | (95,696,389.49) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,821,077.90 | 31,013,841.13 |
| Хуримтлагдсан элэгдэл | (13,164,996.47) | (13,368,331.01) |
| Зам гүүрийн байгууламж | 142,459,712.00 | 142,459,712.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (49,312,977.12) | (60,271,416.48) |
| Бусад үндсэн хөрөнгө | 81,000.00 | - |
| Хуримтлагдсан элэгдэл | (81,000.00) | - |
| БИЕТ БУС ХӨРӨНГӨ | 13,154,000.00 | 9,104,000.00 |
| Бусад биет бус хөрөнгө | 13,154,000.00 | 9,104,000.00 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,763,655,918.63 | 1,608,053,399.90 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,839,648,389.93 | 1,662,139,379.98 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 10,288,168.40 | 19,631,162.00 |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 10,288,168.40 | 19,631,162.00 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 10,288,168.40 | 19,631,162.00 |
| Засгийн газрын хувь оролцоо | 295,620,776.97 | 295,620,776.97 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 124,618,252.87 | 124,618,252.87 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,409,121,191.69 | 1,222,269,188.14 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,829,360,221.53 | 1,642,508,217.98 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,839,648,389.93 | 1,662,139,379.98 |

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | |
|--|----------------|------------------|
| Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох | 604,800.00 | 950,400.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 112,856,466.65 | 158,785,110.36 |
| Бусад зардал | 2,011,400.00 | 1,161,500.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 110,845,066.65 | 157,623,610.36 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 5,413,351.78 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 2,551,351.78 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,424.59 | 2,551,351.78 |
| Бусад урсгал шилжүүлэг | | 2,862,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 2,862,000.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 894,700,663.64 | 1,079,565,012.69 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 244,394,468.05 | (78,561,347.98) |
| Хөрөнгө худалдсаны гарз | - | 108,290,655.57 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 108,290,655.57 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 244,394,468.05 | (186,852,003.55) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан СТА-3 (төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|--|----------------|----------------|
| Татаас, санхүүжилтийн орлого | 770,932,056.40 | 908,285,976.49 |
| Орон нутгийн төсвөөс | 70,131,350.00 | 50,332,600.00 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас | 700,800,706.40 | 857,953,376.49 |
| Бараа, үйлчилгээний орлого | 900,000.00 | - |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 900,000.00 | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 771,832,056.40 | 908,285,976.49 |
| Ажиллагчидтай холбогдсон зардал | 591,220,066.45 | 737,212,007.22 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 525,032,666.45 | 654,300,439.22 |
| Үндсэн цалин | 288,737,301.36 | 355,596,834.22 |
| Нэмэгдлүүд | 190,513,118.44 | 219,907,467.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 17,104,868.00 | 30,830,916.00 |
| Урамшуулал | 28,677,378.65 | 47,965,222.00 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 66,187,400.00 | 82,911,568.00 |
| Тэтгэврийн даатгал | 45,041,781.00 | 57,092,010.00 |
| Тэтгэмжийн даатгал | 6,476,335.00 | 6,492,015.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 2,450,000.00 | 3,201,748.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 2,450,000.00 | 3,211,804.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 9,769,284.00 | 12,913,991.00 |
| Бараа, үйлчилгээний урсгал зардал | 176,879,263.61 | 160,023,193.20 |
| Тогтмол зардал | 59,780,625.41 | 42,790,248.22 |
| Гэрэл цахилгааны зардал | 2,996,019.41 | 3,740,848.22 |
| Түлш, халаалтын зардал | 54,850,250.00 | 37,049,400.00 |
| Цэвэр, бохир усны зардал | 1,934,356.00 | 2,000,000.00 |
| Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал | 62,861,785.20 | 69,234,514.98 |
| Эм | 50,982,385.20 | 58,144,764.98 |
| Хоол | 9,906,400.00 | 9,325,750.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,973,000.00 | 1,764,000.00 |

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | |
|--|-----------------------|-----------------------|
| Хангамж бараа үйлчилгээний зардал | 29,891,696.00 | 34,706,291.00 |
| Бичиг хэрэг | 3,655,150.00 | 3,690,450.00 |
| Тээвэр, шатахуун | 16,224,596.00 | 19,301,591.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,375,000.00 | 3,467,450.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 768,500.00 | 760,000.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,868,450.00 | 7,486,800.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 11,799,800.00 | 4,991,000.00 |
| Урсгал засвар | 11,799,800.00 | 4,991,000.00 |
| Томилолт, зочны зардал | 4,481,000.00 | 2,954,000.00 |
| Дотоод албан томилолт | 4,481,000.00 | 2,954,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,947,557.00 | 4,185,639.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,342,757.00 | 3,125,739.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 950,400.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3,116,800.00 | 1,161,500.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3,116,800.00 | 1,161,500.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,425.59 | 5,413,351.78 |
| Бусад урсгал шилжүүлэг | 1.00 | 2,862,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1.00 | 2,862,000.00 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,424.59 | 2,551,351.78 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,424.59 | 2,551,351.78 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II) | 768,099,330.06 | 902,648,552.20 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 3,732,726.34 | 5,637,424.29 |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал | 3,241,800.00 | 4,277,000.00 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V) | 3,241,800.00 | 4,277,000.00 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V) | (3,241,800.00) | (4,277,000.00) |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII) | 489,500.75 | 1,360,424.29 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 35,941.57 | 525,442.32 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 525,442.32 | 1,885,866.61 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТА4

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|-------------------------------------|-----------------------------|---------------------------|----------------------|------------------|
| 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 295,620,776.97 | 124,618,252.87 | 1,164,726,723.64 | 1,584,965,753.48 |
| Залруулсан үлдэгдэл | 295,620,776.97 | 124,618,252.87 | 1,164,726,723.64 | 1,584,965,753.48 |
| Тайлант үеийн үр дүн | | | 244,394,468.05 | 244,394,468.05 |
| 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 295,620,776.97 | 124,618,252.87 | 1,409,121,191.69 | 1,829,360,221.53 |

| | | | | |
|--|----------------|----------------|------------------|------------------|
| Залруулсан үлдэгдэл | 295,620,776.97 | 124,618,252.87 | 1,409,121,191.69 | 1,829,360,221.53 |
| Тайлант үеийн үр дүн | | | (186,852,003.55) | (186,852,003.55) |
| 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 295,620,776.97 | 124,618,252.87 | 1,222,269,188.14 | 1,642,508,217.98 |

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан СТА-5-1 (төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ЗӨРҮҮ | ХУВЬ |
|---|-----------------------|-----------------------|----------------------|-------------|
| Татаас, санхүүжилтийн орлого | 868,805,300.00 | 857,953,376.49 | 10,851,923.51 | 98.8 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас | 868,805,300.0 | 857,953,376.49 | 10,851,923.51 | 98.8 |
| Бараа, үйлчилгээний орлого | 525,400.00 | - | 525,400.00 | - |
| Урьд оны үлдэгдлээс | 525,400.00 | - | 525,400.00 | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 869,330,700.00 | 857,953,376.49 | 11,377,323.51 | 98.7 |
| Ажиллагчидтай холбогдсон зардал | 743,960,600.00 | 737,212,007.22 | 6,748,592.78 | 99.1 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 659,642,000.00 | 654,300,439.22 | 5,341,560.78 | 99.2 |
| Үндсэн цалин | 353,936,300.0 | 355,596,834.22 | (1,660,534.22) | 100.5 |
| Нэмэгдэл | 214,943,000.0 | 219,907,467.00 | (4,964,467.00) | 102.3 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 32,828,600.0 | 30,830,916.00 | 1,997,684.00 | 93.9 |
| Урамшуулал | 57,934,100.0 | 47,965,222.00 | 9,968,878.00 | 82.8 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 84,318,600.00 | 82,911,568.00 | 1,407,032.00 | 98.3 |
| Тэтгэврийн даатгал | 57,795,400.0 | 57,092,010.00 | 703,390.00 | 98.8 |
| Тэтгэмжийн даатгал | 6,630,800.0 | 6,492,015.00 | 138,785.00 | 97.9 |
| Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал | 3,315,400.0 | 3,201,748.00 | 113,652.00 | 96.6 |
| Ажилгүйдлийн даатгал | 3,315,400.0 | 3,211,804.00 | 103,596.00 | 96.9 |
| Эрүүл мэндийн даатгал | 13,261,600.0 | 12,913,991.00 | 347,609.00 | 97.4 |
| Бараа, үйлчилгээний урсгал зардал | 118,231,400.00 | 112,241,944.98 | 5,989,455.02 | 94.9 |
| Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал | 70,813,200.00 | 69,234,514.98 | 1,578,685.02 | 97.8 |
| Эм, боох материал | 59,625,700.0 | 58,144,764.98 | 1,480,935.02 | 97.5 |
| Хоол, хүнс | 9,412,500.0 | 9,325,750.00 | 86,750.00 | 99.1 |
| Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 1,775,000.0 | 1,764,000.00 | 11,000.00 | 99.4 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 38,119,700.00 | 34,706,291.00 | 3,413,409.00 | 91.0 |
| Бичиг хэргийн материал | 3,704,900.0 | 3,690,450.00 | 14,450.00 | 99.6 |

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | |
|--|-----------------------|-----------------------|----------------------|-------------|
| Тээвэр, шатахууны зардал | 22,436,400.0 | 19,301,591.00 | 3,134,809.00 | 86.0 |
| Шуудан холбооны зардал | 3,702,800.0 | 3,467,450.00 | 235,350.00 | 93.6 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал | 775,600.0 | 760,000.00 | 15,600.00 | 98.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,500,000.0 | 7,486,800.00 | 13,200.00 | 99.8 |
| Томилолт зочны зардал | 3,500,000.0 | 2,954,000.0 | 546,000.00 | 84.4 |
| Дотоод томилолтын зардал | 3,500,000.00 | 2,954,000.00 | 546,000.00 | 84.4 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 4,627,700.00 | 4,185,639.00 | 442,061.00 | 90.4 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,500,000.0 | 3,125,739.00 | 374,261.00 | 89.3 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 950,400.0 | 950,400.00 | - | 100.0 |
| Маягт хэвлүүлэх зардал | 177,300.00 | 109,500.00 | 67,800.00 | 61.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1,170,800.00 | 1,161,500.00 | 9,300.00 | 99.2 |
| Бусад зардал | 1,170,800.00 | 1,161,500.00 | 9,300.00 | 99.2 |
| <u>Урсгал шилжүүлэг</u> | 7,138,700.00 | 7,139,000.00 | (300.00) | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 2,862,000.00 | 2,862,000.00 | - | 100.0 |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал | 4,276,700.00 | 4,277,000.00 | (300.00) | 100.0 |
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 869,330,700.00 | 856,592,952.20 | 12,737,747.80 | 98.5 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 525,443.32 | 525,443.32 | - | 100.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 1,885,867.61 | - | - |

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан -Орон нутгийн төсөв СТА -5-2
(ТӨГРӨГӨӨР)

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------------------------------------|---------------|---------------|--------------|-------|
| Татаас, санхүүжилтийн орлого | | | | |
| Татаас, санхүүжилтийн орлого | 50,332,600.00 | 47,781,248.22 | 2,551,351.78 | 94.9 |
| Орон нутгийн төсвөөс | 50,332,600.00 | 47,781,248.22 | 2,551,351.78 | 94.9 |
| Бараа ,үйлчилгээний урсгал зардал | | | | |
| Тогтмол зардал | 50,332,600.00 | 47,781,248.22 | 2,551,351.78 | 94.9 |
| Гэрэл цахилгааны зардал | 6,283,200.0 | 3,740,848.22 | 2,542,351.78 | 59.5 |
| Түлш, халаалтын зардал | 37,049,400.0 | 37,049,400.00 | - | 100.0 |
| Цэвэр бохир ус | 2,000,000.0 | 2,000,000.00 | - | 100.0 |

| | | | | |
|-------------------|---------------|---------------|--------------|------|
| Урсгал зардал | 5,000,000.0 | 4,991,000.00 | 9,000.00 | - |
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 50,332,600.00 | 47,781,248.22 | 2,551,351.78 | 94.9 |

ГУРАВ. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитаар 42,790.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа^[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Бүртгэл тайлантай холбоотой:

- Гэрэл цахилгааны зардлын 3,740.8 мянган төгрөг, түлш халаалтын зардлын 37,049.4 мянган төгрөг, цэвэр бохир усны 2,000.0 мянган төгрөгийг тус тус тооцоо үүсгэлгүй шууд зардлаар нягтлан бодох бүртгэлд бүртгэсэнийг залруулав.

Аудитаар залруулагдаагүй нийт 3,063.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,063.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 зөвлөмж хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй холбоотой

Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 3,063.1 мянган төгрөг хасагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй: 13.1.1. даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх"; 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|-------------------------------------|--|------------|----------|-----------------------------------|-----|--------------------------|----------|---------|------------|-----|-----|---------|-----|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Залруулсан | | Тоо | Дүн | |
| | | | | | | | | | Дүн | Тоо | | | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Шарга сумын эрүүл мэндийн төв | Гэрэл цахилгааны зардлын 3,740.8 мянган төгрөг, түлш халаалтын зардлын 37,049.4 мянган төгрөг, цэвэр бохир усны 2,000.0 мянган төгрөгийг тус тус тооцоо үүсгэлгүй шууд зардлаар нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн | 1 | 42,790.2 | | | 1 | 42,790.2 | 1 | 42,790.2 | - | - | - | - |
| | Дүн | 1 | 42,790.2 | | | 1 | 42,790.2 | 1 | 42,790.2 | - | - | - | - |

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | |
|-------------------------------------|--|--------------------------|---------|---------------|-----|-----------------|-----|---------|---------|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Шарга сумын эрүүл мэндийн төв | Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 3,063.1 мянган төгрөг хасагдсан байна | 1 | 3,063.1 | - | - | - | - | 1 | 3,063.1 |
| | Дүн | 1 | 3,063.1 | - | - | - | - | 1 | 3,063.1 |

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|--------------|-------|----------------------------|--|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Өөрчлөлтгүй | Хязгарлалтай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 | |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | 1 | | | | |

Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан
2025.08.28